

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/34

Арвайхээр сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5 дахь заалт, “Төсөв баталж, эрх шилжүүлэх тухай” Эрүүл мэндийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн а/396 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшгийн эрсдлийн үнэлгээгээр өвөлжилт хүндрэх эрсдэлтэй байгаа Баруунбаян-Улаан сумын Эрүүл мэндийн төвд автомашин худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Н.Оюунтуяа -Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

Ц.Батжаргал – Нягтлан бодогч

Гишүүд:

Ю.Ичинноров -Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн дарга

Б.Пүрэвсүрэн -Аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/

Г.Гантөмөр -Оновчтой хөгжил ТББ-ын тэргүүн

2. Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж дүгнэлт, зөвлөмж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг үнэлгээний хороо (Н.Оюунтуяа), тендерийн бичиг баримтыг хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлэн архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэж өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичиг (Ц.Батжаргал) нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

622301146